



Deloitte Onch Audit LLC
15th floor, ICC Tower
Jamiyan Gun Street
Sukhbaatar district, 1st khoroo
Ulaanbaatar, 14240
Mongolia

Tel: +976 7010 0450
Fax: +976 7013 0450
www.deloitte.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тэнгэр Даатгал ХХК-ийн Хувьцаа Җзэмшигч танаа,

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх) -ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдэлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн урьдчилсан тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Бусад

Компанийн 2013 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланг өөр аудитын компани аудитласан ба тус аудитор нь 2014 оны 03 дугаар сарын 28-нд зөрчилгүй дүгнэлт гаргасан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Deloitte Onch Audit LLC
Делоитт Онч Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2015 оны 3 сарын 18

